ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: АХГ-2022/228/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

**Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**
**Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn**
**Аудитын менежер: Б.Сэржмядаг**
**Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn**
**Ахлах аудитор: Б.Нарангэрэл**
**Утас: 261628 Цахим хаяг: narangerelb@audit.gov.mn**
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Энич-Аудит" ХХК**
**Захирал: Г.Чинтуяа**
**Утас: 70002115 Цахим хаяг: enichaudit@gmail.com**

Улаанбаатар хот
2022 он

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................ 7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........................................ 9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................ 12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........................................ 16
3. Аудитын тайлан........................................ 17
3.1 Ерөнхий зүйл........................................ 17
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................ 17
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 18
3.4 Материаллаг байдал ........................................ 18
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................ 18
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................ 19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................ 20
3.8 Аудитын гол асуудал ........................................ 21
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ................ 21
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........................................ 21
3.10 Завсарын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........................................ 21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................ 22
4. Аудитын илрүүлэлт ........................................ 23
4.3 Зөвлөмж........................................ 23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл........................................25

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/293

танай ____________ -ны № ____________ -т

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ М. ДАВААБАТ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт гаргах үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0224 Auditiin 2 Gazar-8.Docx

001050178

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0224 Auditiin 2 Gazar-8.Docx

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*Төгрөгөөр*

| Дансны код | БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **467,753,714.09** | **541,979,315.65** |
| **31** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **-** | **-** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 3121 | Төгрөг | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| **33** | **АВЛАГА** | **172,474,553.38** | **215,669,487.44** |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 14,386,424.01 | 13,894,543.59 |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | 2,227,062.00 | 321,226.00 |
| **335** | **Бусад авлага** | **155,861,067.37** | **201,453,717.85** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 150,752,563.37 | 196,345,213.85 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 5,108,504.00 | 5,108,504.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **295,279,160.71** | **326,309,828.21** |
| **351** | **Түүхий эд материал** | **156,725,264.50** | **179,301,659.50** |
| 35130 | Эм боох материал | 156,725,264.50 | 179,301,659.50 |
| **354** | **Хангамжийн материал** | **138,553,896.21** | **147,008,168.71** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 10,456,662.50 | 16,112,635.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 39,653,422.00 | 40,677,722.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 14,319,800.00 | 14,889,800.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | - | 16,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 74,124,011.71 | 75,312,011.71 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,386,995,092.35** | **2,325,126,692.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,386,995,092.35** | **2,325,126,692.31** |
| **392** | **Биет хөрөнгө** | **2,303,770,105.84** | **2,242,001,705.84** |
| 39201 | Барилга, байгууламж | 3,039,461,171.00 | 3,039,461,171.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,038,708,136.28) | (1,105,935,337.88) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 176,900,000.00 | 176,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (176,900,000.00) | (176,900,000.00) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 1,066,250,269.44 | 1,189,224,761.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (816,401,828.21) | (922,563,700.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 166,988,871.52 | 166,988,871.52 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (117,813,141.63) | (129,367,959.42) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,975,000.00 | 3,275,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (445,500.00) | (544,500.00) |
| 39217 | Номын фонд | 1,463,400.00 | 1,463,400.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **83,224,986.51** | **83,124,986.47** |
| 39301 | Програм хангамж | 131,220,000.00 | 138,220,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (95,878,333.49) | (102,978,333.53) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 47,883,320.00 | 47,883,320.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,854,748,806.44** | **2,867,106,007.96** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **198,041,458.95** | **391,460,893.37** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **198,041,458.95** | **391,460,893.37** |
| 413 | Өглөг | 102,879,808.95 | 336,277,293.37 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 9,231,586.95 | 204,621,429.37 |
| 4136 | Бусад өглөг | 93,648,222.00 | 131,655,864.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 93,242,757.00 | 131,655,864.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 405,465.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **414** | **Урьдчилж орсон орлого** | **95,161,650.00** | **55,183,600.00** |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 95,161,650.00 | 55,183,600.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **2,656,707,347.49** | **2,475,645,114.59** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,656,707,347.49 | 2,475,645,114.59 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 690,350,380.90 | 690,350,380.90 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 690,350,380.90 | 690,350,380.90 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,966,356,966.59 | 1,785,294,733.69 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,966,356,966.59 | 1,991,624,931.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (206,330,197.90) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **2,854,748,806.44** | **2,867,106,007.96** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*Төгрөгөөр*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,113,465,929.00** | **2,254,532,196.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **695,800,229.00** | **746,970,375.00** |
| 1200 | Өмчийн орлого | 654,618,759.00 | 746,970,375.00 |
| 1200042 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 653,423,259.00 | 662,709,775.00 |
| 1200043 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,195,500.00 | 460,600.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 83,800,000.00 |
| 122001 | Тусламжийн орлого | 41,181,470.00 | |
| 122002 | Хандив тусламж /дотоод/ | 41,181,470.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,417,665,700.00** | **1,507,561,821.00** |
| 1310 | Улсын төсвөөс | 1,282,686,900.00 | 1,186,476,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,282,686,900.00 | 1,186,476,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 134,978,800.00 | 321,085,521.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 94,978,800.00 | 321,085,521.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 40,000,000.00 | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **2,399,416,986.08** | **2,460,862,393.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,399,416,986.08** | **2,460,862,393.90** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,323,405,949.72** | **2,359,992,312.47** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,174,217,228.00 | 1,267,901,491.54 |
| 210101 | Үндсэн цалин | 1,174,217,228.00 | 1,267,901,491.54 |
| 210102 | Нэмэгдэл | | |
| 210105 | Гэрээт ажлын цалин | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 271,765,393.86 | 170,615,490.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 233,077,631.49 | 170,615,490.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,745,983.02 | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,796,786.81 | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,922,273.42 | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,222,719.12 | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **28,137,224.00** | **28,141,576.00** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 11,582,102.00 | 4,556,505.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 11,794,638.00 | 18,768,488.00 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 4,760,484.00 | 4,816,583.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **129,320,735.32** | **128,651,138.68** |
| 210401 | Бичиг хэрэг | 58,843,286.00 | 64,124,277.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,984,600.00 | 14,074,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,084,216.32 | 8,912,031.18 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,000,002.00 | 4,337,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,222,090.00 | 4,249,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,186,541.00 | 25,074,730.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 7,879,600.00 |
| **210501** | **Нормативт зардал** | **346,593,774.75** | **314,480,265.99** |
| 210502 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 346,593,774.75 | 314,480,265.99 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,534,035.00** | **954,100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,022,515.00 | |
| 210604 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,160,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 8,351,520.00 | 954,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **30,100,915.00** | **33,709,931.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 30,100,915.00 | 33,709,931.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **84,371,729.00** | **155,426,934.01** |
| | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,824,369.00 | 57,126,339.01 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 356,940.00 | 356,940.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 389,100.00 | 427,813.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 77,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 53,270,320.00 | 87,100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 454,000.00 | 415,842.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 5,000,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **243,364,914.79** | **260,111,384.84** |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,894,392.00 | 67,968,500.00 |
| 210914 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 233,470,522.79 | 192,142,884.84 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **76,011,036.36** | **100,870,081.43** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 35,881,900.00 | 91,299,580.00 |
| 213207 | Тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,881,900.00 | 12,873,880.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,000,000.00 | 78,425,700.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт | 40,129,136.36 | 9,570,501.43 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 40,129,136.36 | 9,570,501.43 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **(285,951,057.08)** | **(206,330,197.90)** |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV) | (285,951,057.08) | (206,330,197.90) |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | (15,097,056.00) | - |
| 225006 | Үнэ төлбөргүй гарсан зардал | (15,097,056.00) | |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **(301,048,113.08)** | **(206,330,197.90)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*Төгрөгөөр*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,178,868,604.00** | **2,070,040,633.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **761,202,904.00** | **562,478,812.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 761,202,904.00 | 562,478,812.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 761,202,904.00 | 562,478,812.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 757,022,059.00 | 561,575,732.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,180,845.00 | 903,080.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,417,665,700.00** | **1,507,561,821.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,282,686,900.00 | 1,186,476,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,282,686,900.00 | 1,186,476,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 134,978,800.00 | 321,085,521.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 94,978,800.00 | 321,085,521.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 40,000,000.00 | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **2,160,665,604.00** | **2,023,566,211.20** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,160,665,604.00** | **2,023,566,211.20** |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,079,232,008.64 | 1,922,374,903.77 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,263,236,306.68 | 1,135,409,213.12 |
| 210101 | Үндсэн цалин | 858,252,561.68 | 774,656,731.12 |
| 210102 | Нэмэгдэл | 319,502,045.00 | 252,736,702.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 85,481,700.00 | 108,015,780.00 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 166,211,285.64 | 108,085,739.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 120,501,338.59 | 74,690,094.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 11,909,808.45 | 8,532,024.97 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 9,276,536.64 | 6,708,019.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 2,131,143.44 | 1,650,509.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 22,392,458.52 | 16,505,090.52 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 28,137,224.00 | 28,141,576.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 11,582,102.00 | 4,556,505.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 11,794,638.00 | 18,768,488.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 4,760,484.00 | 4,816,583.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 111,590,306.32 | 118,506,611.18 |
| 210401 | Бичиг хэрэг | 24,502,300.00 | 15,858,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,984,600.00 | 14,090,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,084,216.32 | 8,912,031.18 |
| 210404 | Ном, хэвлэл | 15,500,000.00 | 46,510,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,222,090.00 | 4,249,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 28,297,100.00 | 28,886,830.00 |
| 2105 | Нормативт зардал | 320,856,549.00 | 249,164,161.47 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 319,461,549.00 | 248,449,161.47 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,395,000.00 | 715,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 27,733,514.00 | 13,783,170.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 6,792,514.00 | 1,370,070.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | 11,041,000.00 | 5,459,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,900,000.00 | 6,954,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 30,100,915.00 | 33,846,131.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 30,100,915.00 | 33,846,131.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 121,471,516.00 | 166,361,002.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 35,407,656.00 | 56,885,657.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 356,940.00 | 356,940.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 389,100.00 | 427,813.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 53,270,320.00 | 87,100,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 454,000.00 | 415,842.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 26,516,500.00 | 16,174,750.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,894,392.00 | 69,077,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,894,392.00 | 69,077,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81,433,595.36 | 101,191,307.43 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 39,077,397.00 | 91,299,580.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,881,900.00 | 12,873,880.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 26,195,497.00 | 78,425,700.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 42,356,198.36 | 9,891,727.43 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 42,356,198.36 | 9,891,727.43 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **18,203,000.00** | **46,474,421.80** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **18,203,000.00** | **46,474,421.80** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **18,203,000.00** | **46,474,421.80** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 18,203,000.00 | 46,474,421.80 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,203,000.00 | 46,474,421.80 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(18,203,000.00)** | **(46,474,421.80)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*Төгрөгөөр*

| Үзүүлэлт | Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **690,350,380.90** | **-** | **2,203,769,899.03** | **2,894,120,279.93** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 63,635,150.64 | 63,635,150.64 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (301,048,113.08) | (301,048,113.08) |
| **2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **690,350,380.90** | **-** | **1,966,356,936.59** | **2,656,707,317.49** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 25,267,995.00 | 25,267,995.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (206,330,197.90) | (206,330,197.90) |
| **2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **690,350,380.90** | **-** | **1,785,294,733.69** | **2,475,645,114.59** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*Төгрөгөөр*

| Код | Үзүүлэлт | Төсөв | Гүйцэтгэл | Дүн |
|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,150,860,000.00** | **1,739,063,384.57** | **411,796,615.43** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,197,693,400.00** | **1,176,624,572.57** | **21,068,827.43** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,197,693,400.00 | 1,176,624,572.57 | 21,068,827.43 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **953,166,600.00** | **562,438,812.00** | **390,727,788.00** |
| 1200041 | Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 953,166,600.00 | 561,535,732.00 | 391,630,868.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 903,080.00 | (903,080.00) |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,150,860,000.00 | 1,739,063,384.57 | 411,796,615.43 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,150,860,000.00 | 1,739,063,384.57 | 411,796,615.43 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 2,115,310,400.00 | 1,703,513,804.57 | 411,796,595.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,297,940,800.00** | **1,135,409,213.12** | **162,531,586.88** |
| 210101 | Үндсэн цалин | 875,076,400.00 | 774,656,731.12 | 100,419,668.88 |
| 210102 | Нэмэгдэл | 345,292,800.00 | 252,736,702.00 | 92,556,098.00 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 77,571,600.00 | 108,015,780.00 | (30,444,180.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **175,222,000.00** | **108,085,739.00** | **67,136,261.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 123,304,400.00 | 74,690,094.49 | 48,614,305.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,979,400.00 | 8,532,024.97 | 4,447,375.03 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 10,383,500.00 | 6,708,019.45 | 3,675,480.55 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,595,900.00 | 1,650,509.57 | 945,390.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,958,800.00 | 16,505,090.52 | 9,453,709.48 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **62,573,900.00** | **28,141,576.00** | **34,432,324.00** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 20,532,500.00 | 4,556,505.00 | 15,975,995.00 |
| 210302 | Түлш, халаалт | 27,557,400.00 | 18,768,488.00 | 8,788,912.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,484,000.00 | 4,816,583.00 | 9,667,417.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **85,356,200.00** | **70,936,611.18** | **14,419,588.82** |
| 210401 | Бичиг хэрэг | 17,911,400.00 | 15,298,250.00 | 2,613,150.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 18,746,000.00 | 13,590,000.00 | 5,156,000.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 9,432,000.00 | 8,912,031.18 | 519,968.82 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,350,000.00 | 4,249,500.00 | 3,100,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 31,916,800.00 | 28,886,830.00 | 3,029,970.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **344,359,500.00** | **265,864,161.47** | **78,495,338.53** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | 341,414,900.00 | 265,149,161.47 | 76,265,738.53 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 2,944,600.00 | 715,000.00 | 2,229,600.00 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **38,352,800.00** | **32,257,591.80** | **6,095,208.20** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,000,000.00 | 19,844,491.80 | 155,508.20 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 10,432,800.00 | 5,459,000.00 | 4,973,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,920,000.00 | 6,954,100.00 | 965,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **38,769,400.00** | **16,218,910.00** | **22,550,490.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 38,769,400.00 | 16,218,910.00 | 22,550,490.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **56,580,800.00** | **37,060,002.00** | **19,520,798.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 29,413,100.00 | 14,684,657.00 | 14,728,443.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 5,000,000.00 | 5,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 750,000.00 | 356,940.00 | 393,060.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 585,000.00 | 427,813.00 | 157,187.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 120,000.00 | - | 120,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 454,000.00 | 415,842.00 | 38,158.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 20,258,700.00 | 16,174,750.00 | 4,083,950.00 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **16,155,000.00** | **9,540,000.00** | **6,615,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,155,000.00 | 9,540,000.00 | 6,615,000.00 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **35,549,600.00** | **35,549,580.00** | **20.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **35,549,600.00** | **35,549,580.00** | **20.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,873,900.00 | 12,873,880.00 | 20.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 22,675,700.00 | 22,675,700.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | (0.00) | 0.00 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 96 | 96 | **-** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 2 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 59 | 59 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 35 | 35 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*Төгрөгөөр*

| Код | ҮЗҮҮЛЭЛТ | Төсөв | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **321,085,521.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | | **321,085,521.00** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | | **265,335,521.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **47,570,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 560,000.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | | 500,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 46,510,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | **4,300,000.00** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | | 4,300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **17,627,221.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 17,627,221.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | | **136,301,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 49,201,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | | 87,100,000.00 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **59,537,300.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 59,537,300.00 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **55,750,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **55,750,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | | 55,750,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 321,085,521.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **321,085,521.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 321,085,521.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлагын үлдэгдэлийн баталгаажуулалт, үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл, төсвийн зардлын хэмнэлт болон шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 04- нээс 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Энич аудит ХХК-ийн ахлах аудитор С.Наранцэцэг, аудитор Д.Уртнасан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Г.Чинтуяа хэрэгжүүлсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн зорилго нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, мэргэжлийн өвчний мэргэшсэн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөдөлмөрийн хүний аюулгүй байдал, амьдралын чанарыг алдагдуулахгүй байхын төлөө тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлж аливаа эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхэд оршино.
Дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг судлах, эрүүл ахуйн хэмжилт хийх, үнэлгээ, дүгнэлт гаргах
- Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, нөхөн сэргээж сувилах
- Хөдөлмөр зохицуулалт, магадлал хийх
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон суртачилгааны ажлыг зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2021 оны санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,460,862.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 24,608.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувь буюу 17,226.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,665.5 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, богино хугацаат өглөг, хуримтлагдсан үр дүн дансууд байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*мянган төгрөг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 172,474.6 | 215,669.5 | 43,194.9 |
| Бараа материал | 295,279.2 | 326,309.8 | 31,030.7 |
| Үндсэн хөрөнгө | 2,384,686.8 | 2,325,126.7 | (59,560.1) |
| Нийт хөрөнгө | 2,852,440.5 | 2,867,106.1 | 14,665.5 |
| Богино хугацаат өр төлбөр | 198,041.5 | 391,460.9 | 193,419.4 |
| Өмч: -Төрийн өмч | 690,350.4 | 690,350.4 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 1,966,357.0 | 1,785,294.7 | (181,062.3) |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 2,852,440.5 | 2,867,106.0 | 14,665.5 |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 215,669.5 мянган төгрөг болж 43,194.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагсадтай холбогдсон авлага 491.9 мянган, татаас санхүүжилтийн авлага 1,905.8 мянган төгрөгөөр буурч, байгууллагаас авах авлага 45,592.6 мянган төгрөгөөр өссөн;
- Бараа материал дансны үлдэгдэл 326,309.8 мянган төгрөг болж, 31,030.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 466,085.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 435,054.8 мянган төгрөгийг зарцуулсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,325,126.7 мянган төгрөг болж, 59,560.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн санхүүжилтээр 46,447.5 мянган, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас шилжүүлсэн 83,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж , 192,142.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэн;
- Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 391,460.9 мянган төгрөг болж, 193,419.4 төгрөгөөр нэмэгдсэн нь 2,011,861.4 мянган төгрөгөөр буурч, 2,205,280.8 мянган төгрөгөөр өссөн;
- Хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэл 1,785,294.7 мянган төгрөг болж, 181,062.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны алдагдлаар буурч, өмнөх үеийн өр төлбөрийг төлсөн 25,267.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн залруулах бичилтийг хийсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт 2,889,084.8 мянган төгрөг, үүнээс нийт зардалд 2,889,084.8 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 738,224,8 мянган төгрөгийг бууруулан 2,150,860.0 мянган төгрөгөөр баталсан ба тайлант онд төсвийн тодотгол хийгдээгүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэхээр хөдөлмөр эрхлэлтийн бодлого удирдлага 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээнд улсын төсвөөс 1,197,693.4 мянган, үндсэн үйл ажиллагааны орлогоос 953,166.6 мянган, нийт 2,150,860.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,186,516.3 мянган, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 562,438.8 мянган, нийт 1,748,955.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж , урсгал зардалд 1,739,063.4 мянган төгрөгийг зарцуулж, 9,891.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 391,630.9 мянган төгрөгөөр биелүүлээгүй нь Ковид 19 цар тахалын улмаас улс орон даяр хөл хорио тогтоож төлөвлөгөөт гэрээт ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлд 1,739,063.4 мянган төгрөг буюу нийт 80.9 хувийн биелэлттэй байгаа нь баталсан төсвөөс 21,068.8 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан.

Мөн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 229,667.8 мянга, байр ашиглалтын зардлыг 34,432.3 мянга, хангамж, бараа материалын зардлыг 14,419.6 мянга, норматив зардлыг 78,495.3 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 6,095.2 мянга, томилолт, зочны зардлыг 22,550.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 19,520.8

мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,615.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл*

*мянган төгрөг*

| Д/Д | Үзүүлэлт | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 72102 | Хөдөлмөр эрхлэлтийн бодлого удирдлага | 2,150,859.98 | 1,739,063.38 | (411,796.60) | 80.9% |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,115,310.40 | 1,703,513.80 | (411,796.60) | 80.5% |
| 1.2 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 35,549.58 | 35,549.58 | - | 100% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд НДҮЗ-ийн 2017 оны 10 тогтоолоор баталсан “Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2021 оны төлөвлөгөө”-ний хүрээнд НДЕГ-тай хийсэн гэрээт ажлыг хэрэгжүүлэхэд 321,125.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 47,570.0 мянга, норматив зардал 4,300.0 мянга, томилолт, зочны зардал 17,627.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 136,301.0 мянга, бараа үйлчилгээний зардал 59,537.3 мянга, бусад урсгал шилжүүлэгт 55,750.0 мянга, нийт 321,085.5 мянган төгрөгийн зарцуулж, 40.0 мянган төгрөгийг улсын төсөвд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний хэрэгжилт 90.7 хувьтай байгаа нь Ковид 19 цар тахлын улмаас төлөвлөгөөт үзлэгийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалжээ.

Тус хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал болон нийт зардалд 2,150,860.0 мянган төгрөгийг төсөвлөснөөс гүйцэтгэлээр нийт 1,739,063.4 мянган төгрөгийг зарцуулж 80.9 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 9.8 хувийн зөрүүтэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах

ерөнхий чиглэл"-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд үйл ажиллагааны зардлын 19.1 хувь буюу 411,796.6 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв нь нийт 5,751,442.5 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 835,799.3 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож, 5 саяас дээш орлого, зарлагын 23,675.7 мянган төгрөгийн 2 мэдээг мэдээлээгүй зөрчилтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсарын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 3,000.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илрүүлж, жилийн эцсийн аудитаар энэ зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 албан шаардлагын биелэлт 58 хувь, 8,972.3 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 93 хувьтай байна.

*Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт*

*мянган төгрөг*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | - | 1 | - | 1 | - | 58,0 |
| Зөвлөмж | 3 | 8,972.3 | 2 | 8,972.3 | - | - | 93,0 |
| **Нийт дүн** | **5** | **8,972.3** | **2** | **8,972.3** | **1** | **-** | **75.5** |

Хэрэгжүүлээгүй албан шаардлага нь 2010-2015 оны хооронд үүссэн 12 харилцагчийн 22,651.8 мянган төгрөгийн найдваргүй авлагатай холбоотой асуудал байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд урьдчилан сэргийлэх үзлэг цар тахлын нөлөөнөөс хойшлогдож, харилцагч байгууллагатай хийсэн гэрээт ажлын үлдэгдэл төлбөр бүрэн төлөгдөөгүйн улмаас байгууллагаас авах авлагын үлдэгдэл нь өмнөх оноос 45,592.6 мянган төгрөгөөр өссөн байгааг дараагийн аудитаар үзнэ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,276.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3,000.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 9,276.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй нийт алдаа, зөрчил 12,276.6 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 24,608.6 мянган төгрөгөөс 12,332.0 мянган төгрөгөөр бага тул Зөрчилгүй дүгнэлт өгсөн.

### 4.1 Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага

Өмнөх оны аудитаар  2010-2015 онд үүссэн 12 харилцагчийн 22,651.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар өгсөн  албан шаардлагыг  бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн  6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т” Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.”  гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх , эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлийг хангахгүй  байна.

> Шийдвэрлэсэн нь: Хүчин төгөлдөр болсон албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй . Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөх.

### 4.2 Албан шаардлага

1. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 391,630.9 мянган төгрөгөөр буюу 41,1 хувиар биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 6.2.3 заалт "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй  байна.

> Шийдвэрлэсэн нь:  Байгууллагын  үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх зохистой арга хэмжээг хэрэгжүүлдэг байх. Албан шаардлага өгөх.

2. Байгууллагынхүний хөгжил" сэдэвт сургалтыг ажиллагсдад танхимаар зохион байгуулж, 3,000.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд сургалтыг цахимаар явуулж, төсвийг хэмнэж ажиллаагүй.

Энэ нь Монгол улсын засгийн газрын 2021.02.17 ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1 заалт "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх...", 1.5 " салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт, шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний ...зардлыг хэмнэх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлийн хангахгүй байна.

> Шийдвэрлэсэн нь:  Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажилладаг байх. Албан шаардлага өгөх .

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. *Авлагатай холбоотой асуудал*

*Илрүүлэлт:*

Байгууллага нь 3 харилцагчтай холбоотой үүссэн 9,276.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хууль 6.4.8 заалт "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6 заалт "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна. гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй , эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Төсвийг зохистой удирдаж авлага өглөг үүсгэхгүй байх, авлагын үлдэгдэлийг тооцоо нийлж баталгаажуулах ажлыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

*мянган төгрөг*

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв | АХГ-2022/228/НА-СТА-ТХН | Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 391,630.9 мянган төгрөгөөр буюу 41,1 хувиар биелүүлээгүй байна. | Байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх зохистой арга хэмжээг хэрэгжүүлдэг байх. | 1 | | | | | | 1 | | | | | |
| 2 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төв | АХГ-2022/228/НА-СТА-ТХН | Байгууллагын хүний хөгжил" сэдэвт сургалтыг ажиллагсдад танхимаар зохион байгуулж, 3,000.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд сургалтыг цахимаар явуулж, төсвийг хэмнэж ажиллаагүй. | Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажилладаг байх. | 1 | 3,000.0 | | | | | 1 | 3000.0 | | | | |
| 3 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эхүүл | АХГ-2022/228/НА-СТА-ТХН | Өмнөх оны аудитаар 2010-2015 онд үүссэн 12 харилцагчийн 22,651.8 мянган төгрөгийн авлагыг | Хүчин төгөлдөр болсон албан шаардлагыг хугацаанд нь биелүүлэдэг байх. | 1 | | | | | | 1 | | 1 | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн төв | | барагдуулахаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. | | | | | | | | | | | | | |
| 4 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эхүүл мэндийн төв | АХГ-2022/228/НА-СТА-ТХН | Байгууллага нь 3 харилцагчтай холбоотой үүссэн 9,276.6 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. | Төсвийг зохистой удирдаж авлага өглөг үүсгэхгүй байх, авлагын үлдэгдэлийг тооцоо нийлж баталгаажуулах ажлыг хэрэгжүүлэх. | 1 | 9,276.6 | | | | | | | | | 1 | 9,276.6 |
| Дүн | | | | | 4 | 12,276.6 | | | | | 3 | 3,000.0 | 1 | | 1 | 9,276.6 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эхүүл мэндийн төв | АХГ-2022/228/НА-СТА-ТХН | Шилэн дансны цахим хуудсанд нийт 5,751,442.5 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулахаас 835,799.3 мянган төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож, 5 саяаас дээш орлого, зарлагын 23,675.7 мянган төгрөгийн 2 мэдээг мэдээлээгүй байна. | Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах | 1 | | | | | | 1 | | 1 | | | |
| Дүн | | | | | 1 | | | | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | 5 | 12,276.6 | | | | | 4 | 3,000.0 | 2 | | 1 | 9,276.6 |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 29/А0150058 Улаанбаатар хот
АХГ-2022/228/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасан аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор хийсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харилцагч байгууллагатай байгуулсан Т/21/61 тоот гэрээний дагуу "Байгууллагын хүний хөгжил" сэдэвт сургалтыг танхимаар зохион байгуулж 3,000,000 төгрөгийн зардлыг гаргасан.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх...", 1.5 " салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт, шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний ...зардлыг хэмнэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж, төсөвт зардлыг хэмнэж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М. Даваабат, ерөнхий нягтлан бодогч С. Баяртулга нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР Д.УРТНАСАН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Albun Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-59.Docx

001080173

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 30/А0150058 Улаанбаатар хот
АХГ-2022/228/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасан аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор хийсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 391,630,868 төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлэх зохистой арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М.Даваабат, ерөнхий нягтлан бодогч С. Баяртулга нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.СЭРЖМЯДАГ |
| ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР | Д.УРТНАСАН |

9006109
9019120396

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-58.Docx

001080170

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 28/А0150058 Улаанбаатар хот
АХГ-2022/228/НА-СТА-ТШ3

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасан аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор хийсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар 2010-2015 онд үүссэн 12 харилцагчийн 22,651,796.10 төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага өгсөн болович 2021 онд бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг зөрчсөн алдааг давтан гаргаж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2, гэсэн заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.2 " Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Л.Амартүвшинд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М. Даваабат, ерөнхий нягтлан бодогч С.Баяртулга нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.СЭРЖМЯДАГ |
| ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР | Д.УРТНАСАН |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-60.Docx

001080175

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 27/А0150058 Улаанбаатар хот
АХГ-2022/228/НА-СТА-ТШ3

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасан аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор хийсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 5,751,442,500 төгрөгийн мэдээллийг ил тод байршуулахаас 835,799,300 төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 5 саяас дээш орлого, зарлагын 23,675,750 төгрөгийн 2 мэдээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар албан шаардлага хүргүүлсэн боловч алдаа, зөрчлийг 2021 онд давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг зөрчсөн алдааг давтан гаргаж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2 заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Зөрчил гаргасан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн ерөнхий нягтлан бодогч С.Баяртулгад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн захирал М.Даваабатад даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.СЭРЖМЯДАГ |
| ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР | Д.УРТНАСАН |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-61.Docx

001080179

# ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ